

БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭТ ЗҮЙЛ: “ЗӨВ ХАНДЛАГА, ЗӨВ ЗАН ҮЙЛ ”

МЭНДЛЭХ, ХҮНДЛЭХ ЁС БОЛОН БУСАДТАЙ ХЭРХЭН ЗӨВ ЗОХИСТОЙ ХАРИЛЦАХ ТАЛААРХ ЁС ЗҮЙН ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

НЭГ. ЁС ЗҮЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Ёс зүй хэмээх ойлголт нь эртний Грекийн “ethos” буюу **хамтран амьдрах, оршин амьдрах газар** гэдэг утгатайгаар илэрхийлэгддэг.

Орчин үед энэхүү ойлголт нь хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг гэх шинэ утга агуулгатай болсон.



Тодорхойлбол, ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах, хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах, хүнтэй харилцах соёл сайн сайхан зан үйлийн уламжлалт хэм хэмжээний нэгдмэл системийг хэлдэг гэж болно.

Аливаа байгууллагын ёс зүйн хэм хэмжээ нь ажилтан албан хаагчдын харилцааны түвшингээс эхлэн тодорхойлогддог. Тухайн нэг албан хаагчийн аль алба, хэлтэс, газрын дарга гэдгээс үл хамааран хамт олныхоо урам зоригийн түлхүүр нь гэдгээ ухамсарлан мэдрэх хэрэгтэй.

Хүн бүрийн мэддэг зүйл боловч та бидний өдөр тутмын амьдралд энгийн хэрнээ онцгой ач холбогдол өгдөг үйлдлүүд хийгдэж байдгийг мартаж болохгүй юм.

Харилцааны соёл нь хүмүүс хоорондоо мэнд мэдэлцэх явдлаас эхэлдэг. Мэндлэх нь ойр дотны шинж, сэтгэлээ нээх анхны хэлбэр төдийгүй улмаар харилцан ойлголцох үзэл, оюун санааны нэгдмэл байдлыг хэвшүүлэн тогтоох үндэс болж өгнө.

ХОЁР. МЭНДЛЭХ ЁСНЫ ТАЛААР

Хүмүүс эрт дээр үеэс эхлэн мэндчилгээний олон хэлбэрийг бий болгон хэрэглэж заншжээ. Мэндчилгээ нь улс, үндэстнүүдийн онцлогоос хамаарч янз бүр байдаг. Тухайлбал, дорно зүгийнхэн хоёр гараа урдаа барьж биеэрээ мэхийн ёсолдог бол европчууд зүүн гараараа малгайгаа өргөж толгойгоо үл мэдэг мэхийн мэндчилдэг байх жишээтэй. Зарим нэг улсад бие биеийнхээ хамрыг илж мэндэлдэг бол өөр нэг улсад цээжээ дэлсэж мэндэлдэг сонин ёс заншил ч байдаг аж.



Мэндлэх гэдэг нь бэлгэ дэмбэрэлтэй үг ба зохих хөдлөл барилаар бие биеийнхээ амар мэндийг асуух заншил юм. **“Амны бэлгэ хаашаа бол ашдын бэлгэ тийшээ”** гэсэн цэцэн үг байдаг.

Монголчууд хаана, хэзээ уулзсан ч таних, танихгүй хүнийг ялгахгүй бэлгэ дэмбэрэлтэй үг болон зохих хөдлөл барилыг хавсаргаж бие биеийнхээ амар мэндийг асуун мэндчилдэг. Үүнийг амар асуух, амар айлтгах, амар эрэх, мэнд мэдэх, мэнд дэвшүүлэх гэхчлэн адилгүй нэрлэдэг.

МЭНДЛЭХ ЁС бол монголчуудын харилцан халамжлах, харилцан хүндэтгэх сайхан сургаал бөгөөд нөхөрсөг дотно харилцааных нь бодит илрэл мөн.

Иймээс мэндлэх ёс бол монголчуудын боловсон ёсорхог зан сургаалын чухал агуулга болохын зэрэгцээ оюуны соёлын чухал бүрэлдүүн хэсэг нь болно. **Мэндлэхдээ ямар ч байдалд үе доор буюу насаар дүү хүн урьдаар мэнд мэддэг бөгөөд мэндэлж байгаа хүнийхээ өөдөөс төвлүүн харж намуун дуугаар мэнд асуудаг.** Мэнд мэдэхэд заавал бүтэн өгүүлбэрээр хэлдэг бөгөөд мэнд асуусан үед мэнд хүлээсэн хүн заавал хариу мэндчилж мөн бүтэн өгүүлбэрээр хариулдаг ёстой

Монголчууд бидний хувьд ихэд тайван, баясгалантайгаар намуун зөөлнөөр мэндэлдэг уламжлалт заншилтай. Бидний өвөг дээдэс **“Мэндлэх гэгч мөнхийн ёс”** хэмээн сургасан нь монголчууд эрт үеэс харилцааны өндөр соёлыг чухалчилж ирсэнийг гэрчилнэ.

- Өглөө бүр хамтран ажилдаг нөхөд чинь таны ямар хувцас өмссөн гэдгээс илүүтэй сэтгэл санаа нь хэр өөдрөг, хэр ууртай, сайхан муухай ааштай байгааг чинь тандахаар ажиглан хардаг. Ажлынхаа хаалгаар орсон нь л бол та өөрийгөө хамт олныхоо тухайн өдрийн ажил, араншингийн эхлэл болж байгаагаа санах хэрэгтэй.
- Заавал даргатай эхэлж мэндлэх ёстой гэсэн хууль байхгүй. Энд нас, хүйс, албан тушаалын ангилал, зэрэг дэв, цолны асуудал яригдах хэдий ч зарим тохиолдолд дарга, удирдагч хүн ажилтантайгаа түрүүлж чин сэтгэлээсээ болохгүй гэж. Энэ үед албан хаагч өөрийгөө даргадаа үнэлүүлдэг бөгөөд байгууллагадаа, хамт олондоо хэрэгтэй хүн гэдгээ мэдэрч хөдөлмөрийн бүтээмж нь эрс нэмэгддэг байна. Мэндэлсэнгүйд нь ундууцахын оронд та түрүүлж мэндэлэхэд дараа нь тантай тухайн алба хаагч өдөр тутам сэтгэл гарган мэндийг тань эрэх болно. Сайхан мэндчилгээ нь харилцааны эерэг суурь болдог.
- Эрэгтэй хүн эмэгтэй хүнтэй мэндлэхдээ гараа халаасандаа хийж амандаа тамхи зууж байх нь зохимжгүй. Харин эмэгтэй хүн халаасандаа гараа хийсэн байж болно.
- Ямар ч хэлбэрээр мэндлэхдээ нүүрэндээ сайхан инээмсэглэл тодруулбал цаад хүнээ гүн хүндэлсний илэрхийлэл болно.
- Эрэгтэй хүн мэхийн ёслохдоо малгайгаа өргөх буюу авч мэндэлдэг. Ингэхдээ берет гэж нэрлэдэг дугуй малгай, биеийн тамирын малгай, өвлийн үслэг малгай өмссөн тохиолдолд заавал ингэх шаардлагагүй. Хариуд нь эмэгтэй хүн толгойгоо дохиж нүүрэндээ инээмсэглэл үзүүлж мэндэлбэл илүү соёлтой болно.
- Таних, танихгүй олон хүн цугларсан танхимд орохдоо нийтэд хандан толгой дохиж мэхийн ёслоод дараа нь өөрийн танил хүмүүстэйгээ гар барьж мэндэлдэг.
- Гудамж, талбай, гэр орон, албан байгууллага, олон нийт, үзвэр үйлчилгээний газар, хаана ч гэсэн хүнтэй мэндлэхдээ бусдын анхаарлыг татахуйц чанга хашгирах, сэтгэлийн хөөрлөө илэрхийлэх, гар, малгай, таягаараа даллах нь зохимжгүй.
- Эрэгтэйчүүд хүнтэй мэндлэхдээ баруун гарынхаа бээлийг тайлдаг бол эмэгтэй хүн заавал ингэх шаардлагагүй. Хэрэв эмэгтэй түрүүлж бээлийгээ тайлж мэндэлбэл энэ нь таныг гүн хүндэтгэсний илрэл болно.
- Эмэгтэй хүн эхэлж гараа өгөөгүй тохиолдолд түүнтэй заавал гар барих гэж зүтгэх нь утгагүйг эрэгтэйчүүд анхаарах ёстой.
- Хамт ажилладаг болон танил хүмүүс өөр хоорондоо амар мэндээ асууж мэндлэхдээ өдөр тутмын ярианд элбэг хэрэглэдэг **“Сайна байна уу”, “Өдрийн мэнд хүргэе”, “Өглөөний мэнд хүргэе”** мэндийн үгсийг ашигладаг.

**ТА БҮГД ЭНГИЙН ХИРНЭЭ ХАРИЛЦААНЫ ЧУХАЛ ҮЙЛДЭЛ БОЛОХ
МЭНДЛЭХ ЁСЫГ БҮҮ УМАРТААРАЙ**

ЁС ЗҮЙН ХОРОО